



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ II ТӨСӨЛ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛЫН ТӨЛӨӨХ
ХАМТЫН САНААЧИЛГА, ТҮНШЛЭЛ

НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭ



Тогтвортой хөгжлийн боловсролын төлөөх
ХАМТЫН САНААЧИЛГА ТҮНШЛЭЛ

**ТХ, ТХЗ, ТХБ ба
Монгол Улсын хөгжлийн бодлого,
төлөвлөлт, хэрэгжилт, санаачилга
үндэсний цахим зөвлөгөөн**

2021.05.04

Илтгэгч:

*Д.Сүрэнчимэг, Ph.D,
Удирдлагын Академийн
захирал*



**Тогтвортой хөгжлийн боловсрол
институтчилэл, түншлэл**

ИЛТГЭЛИЙН АГУУЛГА



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛЫН ТӨЛӨВ
ХАМТЫН САНААЧИЛГА ТҮНШЭЭЛ

Тогтвортой хөгжлийн
үзэл баримтлал дэлхий
дахинд



Тогтвортой хөгжлийн үзэл
баримтлалын хэрэгжилт-
үүрэг оролцоо



Бид бусад улс орноос
юу суралцах вэ?



01

02

03

04

05

06

Тогтвортой хөгжлийн
үзэл баримтлал
Монгол Улсад



Тогтвортой хөгжлийн
үзэл баримтлалын
үнэлэлт, дүгнэлт



Тогтвортой хөгжлийн
үзэл санаа:
Институтчилэл, түншлэл,
санал, зөвлөмж





Тогтвортой хөгжлийн боловсролын төлөв
ХАМТЫН САНААЧИЛГА ТҮНШЭЭ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ – ДЭЛХИЙ ДАХИНД

Тогтвортой
хөгжлийн
тулгуур:

5

People – Хүмүүн төрөлхтөн
Planet – Эх дэлхий
Prosperity – Хөгжил цэцэглэлт
Peace – Энх тайван
Partnership – Хамтын ажиллагаа



1972

Стокгольм хотноо
“Хүн төрөлхтөн ба
байгаль орчин”
чуулга уулзалтыг
зохион байгуулж,
26 зарчмыг
тодорхойлсон.

Брундтландын
комиссын тунхаглал
буюу “Манай
нийгмийн ирээдүй-
тогтвортой
хөгжил” хэмээх
баримт бичгийг
баталсан.

1987

1992

Рио Де
Жанейрогийн
“Тогтвортой
хөгжил”
тунхаглал
батлагдаж, улмаар
2016-2030 онд
баримтлах
“Тогтвортой
хөгжлийн үзэл
баримтлал”-ыг
томъёолон гаргасан.

“Хөгжлийн
хөтөлбөр 21”-
хөтөлбөрийг
үргэлжлүүлэн
хэрэгжүүлэх
хөтөлбөрийг
баталсан.

1997

2012

“Бидний хүсэж буй
ирээдүй” баримт
бичигтээ сүүлийн 20
жилд хөгжлийн
асуудлаар
баримталж ирсэн
бодлого, шийдвэр,
арга хандлагад
дүгнэлт хийсэн.

2015

“Тогтвортой
хөгжлийн үзэл
баримтлал” хэмээх
баримт бичигт
“Хөгжлийн гадна
хэнийг ч үлдээлгүй
хөгжих” агуулга
бүхий 17 зорилго,
169 зорилтыг
боловсруулан
багтаажээ.



Тогтвортой хөгжлийн боловсролын төлөв
ХАМТЫН САНААЧИЛГА ТУНШАЛ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ – ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН
БОЛОВСРОЛ II
ТӨСӨЛ



Нийгэм, эдийн засаг, байгаль орчны харилцан шүтэлцээтэй хөгжүүлэхэд чиглэсэн тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай уялдан гарсан шинэ тутам хандлагын нэг нь тогтвортой хөгжлийн боловсрол хэмээх ойлголт юм.



Эдгээр баримт бичигт сүлжээ, хамтын ажиллагаа, түншлэл, оролцоо, уялдаа холбоо, дэмжих бодлогын агуулга, боловсролын тогтолцоо зэрэг асуудлыг хамарсан зорилго, зорилт, үйл ажиллагааг тусгаж, **боловсрол нь Тогтвортой хөгжилд хүргэх үндсэн арга хэрэгсэл** хэмээн тодорхойлжээ.

- ✂ 1972 – НҮБ-ын Хүний хүрээлэн буй орчин Стокгольмын хурлын тунхаглал
- ✂ 1975 – НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн “Хүрээлэн буй орчны боловсролын үйлийн хүрээ”
- ✂ 1990 – НҮБ-ын Бүх нийтийн боловсролын Дэлхийн (Жонтмейны) тунхаглал
- ✂ 1992 – НҮБ-ын Риогийн тунхаглал болон “Хөгжлийн хөтөлбөр-21”
- ✂ 2002 – НҮБ-ын Иоханнесбургийн тунхаглал
- ✂ 2004 – ЮНЕСКО, НҮБ-ын ТХБ-ын 10 жил
- ✂ 2009 – ЮНЕСКО-ийн ТХБ-ын Бонны тунхаглал

Эдгээр баримт бичигт улс орнууд ТХБ-ыг хэрэгжүүлэхдээ ТХ-ын нийтлэг үнэт зүйлсээс гадна бүс нутаг, үндэстэн, угсаатан, орон нутгийн хэрэгцээ, соёлын онцлогоос үүдэлтэй шийдвэрлэх асуудлаа дэвшүүлж, шинжлэх ухаанд үндэслэсэн, судалгаанд суурилсан ТХ-ийн төлөө боловсролын тогтолцоогоо хөгжүүлэхийг зөвлөмжилсөн.



Тогтвортой хөгжлийн боловсролын төлөв
ХАМТЫН САНААЧИЛГА ТҮНШЭЭЛ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ – МОНГОЛ УЛСАД

- Тогтвортой хөгжлийн Дэд хороо – УИХ-ын НББСШУ-ны байнгын хорооны дэргэдэх
- Тогтвортой хөгжлийн Үндэсний хороо – Ерөнхий сайд ахладаг
- Үндэсний хөгжлийн газар – Мэргэжлийн удирдлагаар хангах
- Үндэсний статистикийн хороо – Тоо баримтаар хангах
- Ажлын хэсэг – 9 /Ерөнхий сайдын захирамжаар байгуулсан/

- Гадны төсөл, хөтөлбөрүүд – НҮБ-ийн төсөл хөтөлбөрүүд, GIZ

ШХА гол манлайлалтай оролцож ирснийг онцлон тэмдэглэе.

1997-2005

**Бүх нийтийн экологийн
боловсрол үндэсний хөтөлбөр**

Засгийн газрын 1997 оны
255 дугаар тогтоол

1997

Монгол Улсын тогтвортой хөгжлийн стратегийн дагуу нийгмийн шинэ харилцаанд нийцүүлэн боловсролын тогтолцоог бүхэлд нь хамарсан шинэчлэлийг бүрэн агуулгаар нь хэрэгжүүлэх зорилтын хүрээнд албан ба албан бус боловсролын арга, хэлбэрээр бүх нийтийн экологийн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагааны шинэ *механизм бүрдүүлэх*эд оршино.

2014

2014-2020

2021-2030

Ногоон хөгжлийн бодлого

Улсын их хурлын 2014 онд
43 дугаар тогтоол

Ногоон хөгжлийн үзэл санаанд тулгуурласан, иргэдийн оролцоог хангасан эдийн засгийн өсөлтийг бий болгосноор хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалан ирээдүй хойч үедээ өвлүүлж, үр өгөөжийг нь урт хугацаанд хүртэх боломжоор хангах нөхцөлийг бүрдүүлсэн *хөгжингүй улс болно.*

2018

2018-2022

**“Тогтвортой хөгжлийн
боловсрол” Үндэсний хөтөлбөр**

Засгийн газрын 2018 оны
209 дүгээр тогтоол

Бүх нийтэд байгаль орчноо хамгаалах, түүх, соёлын өвийг дээдлэх, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, түүнд дасан зохицох, гамшгийн эрсдэлийг даван туулах, байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээний соёл, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэхэд чиглэсэн тогтвортой хөгжлийн боловсрол эзэмшүүлж, Монгол Улсын *тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах*ад хөтөлбөрийн зорилго оршино.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол

- Монгол Улс 2050 онд нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьдралын чанараар Азид тэргүүлэгч орнуудын нэг болно.
- 9 зорилго, 47 зорилт, 3 үе шаттай
- 9 зорилго: Үндэсний нэгдмэл үнэт зүйл, **Хүний хөгжил**, Амьдралын чанар ба дундаж давхарга, Эдийн засаг, Засаглал, **Ногоон хөгжил**, Амар тайван аюулгүй нийгэм, Бүс орон нутгийн хөгжил, Улаанбаатар ба дагуул хот

Эрхэм зорилго:

- Үндэс язгуур, төрт ёс, өв соёлоо дээдэлж,
- Үндэсний нэгдмэл үнэт зүйлээ эрхэмлэж,
- Хүн төрөлхтний дэвшилтэт ололтыг дэмжиж,
- Хөрст дэлхий, унаган байгалиа хайрлан хамгаалж,
- Амар тайван, хүмүүнлэг нийгмийг цогцлоож,
- Ардчилал, шударга ёсны засаглалыг бэхжүүлж,
- Өөрийгөө тэтгэсэн эдийн засаг нь өрх, иргэн бүрд тэгш, хүртээмжтэй хүрсэн,
- Эрүүл чийрэг, эрдэм боловсролтой, эх оронч, хөрвөх чадвартай, оюунлаг, бүтээлч иргэнтэй улс болж хөгжинө.





ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛЫН ТӨСӨЛ
ХАМТЫН САНААЧИЛАГА ТҮНШЭЭЛ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ХЭРЭГЖИЛТ – ҮҮРЭГ ОРОЛЦОО

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН
БОЛОВСРОЛ II
ТӨСӨЛ

ТББ, ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГА

- ❖ Техникийн мэдлэг, чадавх
- ❖ Орон нутагт хүрч ажиллах боломж, мэдлэг
- ❖ Нийгмийн капитал, Хууль ёсны байдал
- ❖ Хүн төвт үйл ажиллагаа

БИЗНЕСИЙН БАЙГУУЛЛАГА

- ❑ Зах зээлд суурилсан, арилжааны, нэмүү өртөг бий болгох хандлага
- ❑ Брэнд болон хэрэглэгчдэд хүрэх боломж
- ❑ Техникийн болон үйл явцын инноваци
- ❑ Лэл бүтэц, ложистик

ЗАСГИЙН ГАЗАР, ПАРЛАМЕНТ

- Зохицуулах хүрээ: дүрэм журам, лиценз
- Төрийн тогтолцоотой нэгтгэх боломж, Ардчилсан хууль ёс
- Урт хугацааны төлөвлөлт, Чадавхжуулалт
- Газар, Дэд бүтцийг дэмжих зохицуулалт

ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА, НҮБ

- ✓ Техникийн туслалцаа, мэдлэг, туршлага
- ✓ Глобал сүлжээнд нэгдэх боломж
- ✓ Хууль ёсны байдал
- ✓ Улс төрийн шийдэл

ДОНОР БАЙГУУЛЛАГУУД, САНГУУД

- Дэмжлэг
- Санхүүжилт






ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛЫН ТӨЛӨВ
ХАМТЫН САНААЧИЛАГА ТҮНШЭЭЛ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ

- Олон улс орны хувьд үндэсний хэмжээнд зохицуулах байгууллага бий болгох нь ТХБ-ын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үр дүнтэй арга хэрэгсэл гэж үзэж байна.
- Эдгээр зохицуулах байгууллага нь яам хоорондын болон олон талт оролцогч талыг хамрах бөгөөд 2014 оны байдлаар улс орнуудын 80 хувь орчим нь ТХБ-д анхаарлаа хандуулж байна.
- Дээрх улс орнуудын 50 хувь орчим нь Үндэсний хэмжээний зохицуулах байгууллагатай болсон байна.
- Гэсэн хэдий ч ихэнх улс оронд хэрэгжүүлж буй:
 - ☐ Бодлого нь хангалтгүй
 - ☐ Зохицуулалт сул
 - ☐ Оролцоо тодорхойгүй
 - ☐ ТХБ-ын аливаа санаачлагыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэр баталгаажуулаагүй хэвээр байгаа нь сорилт болж байна.

UNESCO (2018). *Issues and trends in Education for Sustainable Development: Education on the move*, p.93



- ❖ ТХ-ийн зорилтын хэрэгжилтийг хянах гол арга механизмын нэг нь “Үндэсний сайн дурын илтгэл” (Voluntary National Report) юм.
- ❖ НҮБ-ын гишүүн орнууд 2016 оноос эхлэн ТХЗ-ын хэрэгжилтийн талаар үндэсний тайлангаа НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн ивээл дор жил бүр зохион байгуулагддаг чуулга уулзалтад танилцуулж ирлээ.
- ❖ Энэхүү чуулга уулзалтаар 2016-2018 онуудад улс орнуудын 115 илтгэлийг хэлэлцсэн. ҮСДИ-ийг 2019 онд танилцуулсан 47 улсын нэг нь Монгол улс юм.

Монгол улсын ТХЗ хэрэгжүүлэлтийн тайлан

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ САЙН ДУРЫН ИЛТГЭЛ 2019-д

- Тогтвортой хөгжлийг хангах үндэс суурь бүрдсэн хэдий ч “төрийн нэгдмэл бодлого, зохицуулалттай байх” зарчмыг хэрэгжүүлж, олон талын оролцоог хангасан илүү оновчтой, нээлттэй хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог бүрдүүлэх
- “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль”-д өөрчлөлт оруулж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагыг байгуулж, яамдын чиг үүргийг шинэчилж, нэгдсэн зохицуулалтыг бий болгох
- ТХ-ийн зорилтын хэрэгжилтийг хангахдаа нэгдсэн зохицуулалтаар, хариуцах чиг үүргийг нь тодорхой болгож, үр дүнг нь хяналтын механизмыг бүрдүүлж, хариуцлагын тогтолцоог уялдуулах
- ТХ-ийн зорилтын хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох үйл явцыг нутагшуулах, орон нутгийн түвшинд гаргах, үр дүнд суурилсан хяналтыг сайжруулж, тогтмолжуулах, төрийн албан хаагчийн хариуцлагын механизмтай уялдуулах
- Урт хугацааны хөгжлийн зорилгыг хангахад санхүүжилтийн хэрэгцээг тооцох, төлөвлөх, төр хувийн хэвшил, гадаад эх үүсвэрээс нэмэлт эх үүсвэрийг бүрдүүлсэн нэгдсэн стратеги боловсруулах

Монгол улсын ТХЗ хэрэгжүүлэлтийн тайлан



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛЫН ТӨСӨЛ
ХАМТЫН САНААЧИЛГА ТҮНШЭЛ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ

Хөгжлийн түвшний хувьд дэлхийн улс орнуудын дотор Монгол Улс ямар эрэмбэтэй байгааг илэрхийлэх судалгааны үр дүнгүүдийн нэг бол Дэлхийн эдийн засгийн форумаас жил бүр гаргадаг “Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан” юм.

**Нийт индекс эрэмбээр
141 орны дотор 102-рт**

Институтчилэл 90-р байр

Ур чадвар 95-р байр

Инновацын чадавх 93-р байр

R&D зардал 103-р байр

ХБО-ы хүчин төгөлдөр гэрээ хэлцэл 56-р байр

Нийгмийн капитал 36-р байр

Е-оролцоо 62-р байр

Төгсөгчдийн ур чадвар 119-р байр

Багшлах явц дахь шүүмжлэлт сэтгэлгээ 114-р байр

Оролцогч талуудын хамтын ажиллагаа 105-р байр



Хараат бус шинжээчдээс бүрддэг Тогтвортой хөгжлийн шийдлийн сүлжээ (the Sustainable Development Solutions Network-SDSN) байгууллага “Тогтвортой хөгжлийн тайлан-2019”-даа НҮБ-ын гишүүн 162 орны ТХ-ийн зорилтуудын хэрэгжилтийг үнэлж, индекс тооцоход Дани, Швед, Финланд, Франц, Австри улс эхний таван байрыг эзэлж, **Монгол Улс 64.7 оноогоор 100 дугаарт** эрэмбэлэгдсэн.

<https://www.sdgindex.org/reports/sustainable-development-report-2019/>

Дэлхийн дээд боловсролын мэдээллийн тэргүүлэх үйлчилгээ үзүүлэгч The Times Higher Education сүлжээ нь **ТХ-ийн зорилтуудыг их, дээд сургуулиуд хэр хэрэгжүүлж**, сорилтыг даван туулах шийдлийг олоход хэр хувь нэмэр оруулж байгааг үнэлж “Нөлөөллийн зэрэглэл 2020” (THE Impact Rankings 2020) гэх эрэмбийг судалгаа, сурталчилгаа, удирдлага гэсэн гурван хүрээгээр тогтоожээ. 2020 онд 85 орны 768 их сургуулийг үнэлсний дотор Шинэ Зеландын University of Auckland тэргүүлж, араас нь Австралийн University of Sydney, Western Sydney University, La Trobe University гэсэн гурван их сургууль удаалжээ.

<https://www.timeshighereducation.com/rankings/impact/2020/partnerships-goals#!/>

ТХ-ийн зорилтуудын хэрэгжилтийг НҮБ-ээс гаргасан шалгуур үзүүлэлтээр харьцуулах нь учир дутагдалтай юм.

Улс орон бүрийн төрийн болон орон нутгийн удирдлага нь тухайн улсын онцлогоос хамааран нэг нэгнээсээ ялгардаг. Гэвч тэдгээрийн ТХ-ийн зорилтыг хэрэгжүүлж буй тогтолцоо, системийг харьцуулан үнэлэх, ТХ-ийн зорилтын хэрэгжилтэд төрийн удирдлагын төвшинд юунд анхаарах хэрэгтэйг мэдэх зорилгоор хэсэг судлаачид тусгай боловсруулагдсан асуултуудаас бүрдсэн **МАТРИКС асуулгын загвар** ашигласан байна.

2019 оны байдлаар нийт 12 багц, 101 дэд үзүүлэлтээр улс орнуудыг жагсаахад Монгол Улс ерөнхий эрэмбээр 141 орны 102 дугаарт жагсав.

World Economic Forum (2019). The Global Competitiveness Report, <http://reports.weforum.org/>

Улс орнуудын засаглалын ялгааг харуулах, ТХ-ийн зорилтуудын гүйцэтгэлийг сайжруулахад тулгарч буй асуудлыг тодорхойлоход тустай нь батлагдсан **МАТРИКС асуулгын загвар**-ыг ашиглаж байна.

Үүрэг/ Бүтэц	А-Шийдвэр гаргах чадамж (decision-making capacity)	В-Холбоотой байдал (connectivity)	С-Мэдлэг ашиглах байдал (knowledge use)
1. Алсын хараа болон зорилт тогтоох	1-A-1. 1-A-2. 1-A-3.	1-B-1. 1-B-2. 1-B-3. 1-B-4.	1-C-1. 1-C-2. 1-C-3.
2. Судалгаа болон тооцоолол	2-A-1. 2-A-2.	2-B-1. 2-B-2. 2-B-3.	2-C-1. 2-C-2. 2-C-3.
3. Стратегийн дэвшил	3-A-1. 3-A-2. 3-A-3.	3-B-1. 3-B-2. 3-B-3.	3-C-1. 3-C-2.
4. Хэрэгжүүлэлт	4-A-1. 4-A-2. 4-A-3.	4-B-1. 4-B-2. 4-B-3.	4-C-1. 4-C-2. 4-C-3.
5. Хяналт, Үнэлгээ, Эргэх холбоо	5-A-1. 5-A-2. 5-A-3. 5-A-4.	5-B-1. 5-B-2. 5-B-3.	5-C-1. 5-C-2.

Тогтвортой хөгжлийн зорилтуудыг биелүүлэх үндэсний болон орон нутгийн засаглалын системийн шинжилгээ: Япон, Индонезийн кейс судалгаа, 2019, Kanaka Morita

Indonesia's National Governance System for SDGs

Decision-making capacity National Connectivity National Knowledge use National



Fig.3 Structure and functions of Indonesia's national governance system for the SDGs

Indonesia's Local Governance System for SDGs

Decision-making capacity Local Connectivity Local Knowledge use Local



Fig.4 Structures and functions of Indonesia's local governance system for the SDGs

Japan's National Governance System for SDGs

Decision-making capacity National Connectivity National Knowledge use National




Fig.1 Structure and functions of Japan's national governance system for the SDGs

Japan's Local Governance System for SDGs

Decision-making capacity Local Connectivity Local Knowledge use Local



Fig.2 Structure and functions of Japan's local governance system for the SDGs



ҮНДЭСНИЙ САЙН ДУРЫН ИЛТГЭЛ 2019
Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилт

**БИД БУСАД УЛС
ОРНУУДААС ЮУ
СУРАЛЦАХ ВЭ?**

УЛС ОРНУУДЫГ СОНГОСОН ШАЛТГААН



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛЫН ТӨСӨЛ
ХАМТЫН САНААЧИЛГА ТҮНШЭЭЛ




✂ **Эстони:** ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан 15 БНУ-ын нэг. Монгол улстай төстэй улс төрийн шилжилтийг даван туулсан. Улс төрийн систем, хөгжлийн хувьд адил төстэй талуудтай улс.



✂ **Финлянд, Швейцарь:** Улсын хөгжил, төрийн тогтолцоо, явуулж буй бодлогын хувьд манай улс үлгэр жишээ авдаг орнууд. ТХ-ийн зорилтуудын хэрэгжилт, энэ хүрээнд байгуулсан тогтолцооны хувьд дэлхийн бусад орнуудад жишиг болсон улсууд.



✂ **Герман:** Монгол улсын эрх зүйн тогтолцоо нь Герман суурьтай олон улсын тогтолцоонд хамаарч, түүний хүрээнд явагддаг.



✂ **Япон:** Хөгжлийн бодлогын хүрээнд Монгол улсын гол түншүүдийн нэг бөгөөд хоёр орны хамтын ажиллагаа өндөр төвшинд хүрсэн.



✂ **Индонез:** Азийн бүс нутагт хөгжлийн төвшин, эдийн засгийн бодлогын хувьд тэргүүлж буй орнуудын нэг. ТХЗ хэрэгжүүлэх хүрээнд Монгол улстай төстэй үе шатанд яваа улс.

ЭСТОНИ



Удирдах, зохицуулах, зангидах

Засгийн газрын дэргэд тогтвортой хөгжлийн “Стратегийн нэгж” байдаг.

Үйл ажиллагааг хариуцан ажиллах түвшинд

ТХ-ийн зорилтын хүрээнд байгуулагдсан 2 үндсэн байгууллага үйл ажиллагааг зохион байгуулдаг.

1. Тогтвортой хөгжлийн яамд хоорондын ажлын хэсэг
2. Эстони улсын Тогтвортой хөгжлийн хороо

Хийсэн ажил

ТХ-ийн Зорилт 2030 хэвлэгдэхээс өмнөх хэрэгжүүлсэн үндэсний бодлого, стратеги нь үүнтэй хэр уялдаж байгааг үнэлэх шийдвэр гаргажээ.

Суралцах зүйл

- Үр дүнтэй удирдлагын тогтолцоо
- ТХ-ийн зориултуудыг үндэсний стратегитай уялдуулсан арга зам
- Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөгөө ТХ-ийн зорилттой хэр уялдсан байгааг тогтоосон шинжилгээ

ФИНЛЯНД



Удирдах, зохицуулах, зангидах

Улс төрийн тогтвортой байдал, алсын хараатай үндэсний хандлага, яамд хоорондын нягт хамтын ажиллагаа, нийгмийн олон салбарын идэвхтэй оролцоо нь Финлянд улсыг ТХЗ-г амжилттай хэрэгжүүлж буй орнуудын нэг болгосон байна.

Үйл ажиллагааг хариуцан ажиллах түвшинд

1. Ерөнхий сайд тэргүүлдэг Тогтвортой Хөгжлийн Үндэсний хороо - ТХЗ-ыг үндэсний хөгжлийн зорилттой уялдуулах, удирдлагаар хангах, хянах үүрэгтэй. Энэ хорооны үйл ажиллагааг дэмжих “ТХ-ийн Экспертүүдийн панел” энэ чиглэлээр мэргэшсэн судлаачид, экспертүүдээс бүрддэг.
2. Финляндын Хөгжлийн Бодлогын Хороо – Финляндын Үндэсний хөгжлийн бодлогуудыг ТХЗ 2030 уялдуулдаг.

Хийсэн ажил

- Оролцоог чухалчилсан.
- ТХ-ийн Үндэсний шинэ стратегиа “ТХ-д нийгмийн хүлээх үүрэг” гэсэн нэртэй гаргасан.
- Стратегиа хэрэгжүүлэхэд оролцоог чухалчилж бүх салбарынхаар гарын үсэг зуруулсан.
- 2016 онд бүх яамдаар ТХ-ийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийн хэмжээг гаргуулан хэлэлцэж баталж ажилласан.

Суралцах зүйл

- Удирдлагын оновчтой тогтолцоо
- Тогтвортой хөгжилд нийгмийн бусад салбарын үүрэг хариуцлагыг тодорхойлсон, үүрэгжүүлсэн байдал

ГЕРМАН



Удирдах, зохицуулах, зангидах

2002 онд Холбооны Засгийн газар “Германы Үзэл баримтлал: Тогтвортой хөгжлийн Бидний стратеги” илтгэлийг гаргасан ба энэ нь улс төрийн шийдвэр гаргалтад баримтлах зарчим болж хувирсан байна. Тогтвортой хөгжлийн үндэсний тогтолцоог Холбооны Канцлер тэргүүлдэг.

Үйл ажиллагааг хариуцан ажиллах түвшинд

1. Канцлерийн дэргэд “Төрийн нарийн бичгийн дарга нарын хороо” ажиллаж бүх яамдын төлөөлөл энэ хороонд ордог. Энэхүү хороо нь ТХЗ-ын хэрэгжилт, үйл ажиллагааны төлөвлөгөөний сайжруулалт, хяналтыг зохицуулах гол хэсэг.
2. ТХ-ийн Парламентийн Зөвлөх хороо нь тогтвортой хөгжлийн асуудлуудыг парламентад танилцуулж, бүх сайд нарын тушаал, тогтоол Тогтвортой хөгжлийн Үндэсний стратегид хэр нийцэж байгааг шалгах, тэдгээрийн хууль зүйн нөлөөг хянах үүрэгтэй.
3. “ТХ-ийн Үндэсний Зөвлөл” нь Засгийн газрын тогтвортой хөгжлийн чиглэлээр авч хэрэгжүүлж буй бодлогыг дэмжих үүрэгтэй бие даасан зөвлөх нэгж. Энэ нэгж нь тогтвортой хөгжлийн талаар ойлголтыг олон нийтэд хүргэх, ТХЗ-ын талаар олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх, тэдгээрийг дэмжих үүрэгтэй.

Хийсэн ажил

ТХ-ийн зорилтуудыг хэрэгжүүлэх Германы тогтолцоонд орон нутгийн болон бусад салбарын оролцоо ихээхэн чухал. Германы 16 муж улс (Lander) Үндэсний тогтвортой Хөгжлийн стратегид оролцож, тодорхой үүрэг хариуцлага хүлээсэн байна.

Суралцах зүйл

- Холбооны тогтолцоотой улсын хувьд муж бүрийг ТХЗ-ыг хэрэгжүүлэх чиглэлд үүрэгжүүлсэн байдал
- ТХ-ийн зорилтуудын хэрэгжүүлэх хамгийн үр өгөөжтэй системийг бүтээсэн. Европын зарим орнууд ТХ-ийн зорилтуудыг хэрэгжүүлэхдээ Германы тогтолцооноос санаа авч ажиллаж байгаа.

ШВЕЙЦАРЬ



Удирдах, зохицуулах, зангидах

Үндэсний хөгжлийн бодлогоо ТХЗ 2030-тай уялдуулж чадсан. ТХЗ-ыг дотоод болон гадаад бүх үйл ажиллагаандаа нягт уялдуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Үйл ажиллагааг хариуцан ажиллах түвшинд

- Хэрэгжилтийн талаар үнэлгээг гаргах, үндсэн зорилт болон өнөөгийн нөхцөл байдлын ялгааг оновчтой тодорхойлох
- Төрийн болон холбооны байгууллагуудын ТХ-ийн зорилтуудын хүрээнд хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлох, нэгдсэн удирдлагаар хангах
- Үндэсний хяналтын /МОНЕТ/ системийг ТХ-ийн зорилтуудтай уялдуулан шинжлэх, мэдээллэх

Хийсэн ажил

- Холбооны зөвлөл үндэсний бүх бодлогод ТХ-ийн зорилтуудыг суурь болгохын тулд 2016-2017 онд Шилжилтийн шат гэх үйл ажиллагааны хөтөлбөрийг гаргасан.
- 2016 онд “ТХЗ 2030” хэрэгжүүлэх үндсэн баримт бичиг болох Тогтвортой хөгжлийн стратеги 2016-2019 боловсруулан, үндсэн 9 салбарт хэрхэн ТХЗ-той уялдуулан, энэ хүрээнд алсын хараа, зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж баталсан.
- ТХЗ-ыг гадаад бодлоготойгоо уялдуулах болсон. Швейцарийн Гадаад бодлогын стратеги 2016-2019 баримт бичигт тусгаснаар тогтвортой хөгжил, түүнийг дэмжих үндсэн 4 чиглэлийн нэгээр нэрлэгдсэн.

Суралцах зүйл

- Гадаад бодлогын хүрээнд тогтвортой хөгжлийг дэмжих
- ТХЗ-ыг үндэсний зорилтын хүрээнд хэрэгжүүлэх

ЯПОН



Удирдах, зохицуулах, зангидах

ТХЗ-ын хэрэгжилтийг дэмжих хууль эрх зүйн тогтоол гаргаагүй. ТХЗ дэмжих газрыг Ерөнхий сайд ахаж, бусад сайдууд энэ хооронд ажилладаг байхаар 2016 оны 5-р сард байгуулсан. Энэ газрын хүрээнд ТХЗ-ыг дэмжих, хэрэгжилтийг хянах уулзалтуудыг зохион байгуулахаар шийдвэрлэсэн.

Үйл ажиллагааг хариуцан ажиллах түвшинд

Энэ газрын үйл ажиллагааг Японы Гадаад хэргийн яам болон Хэрэг эрхлэх газар зохион байгуулж, чиглүүлдэг. Энэ газарт хувийн салбар, академиуд болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл багтах бөгөөд аль болох олон салбарын төлөөлөл байлгах талаас ажилладаг.

Хийсэн ажил

- Эдгээр уулзалтуудын үр дүнд 2016 оны 12-р сард “ТХ-ийн зорилтуудын хэрэгжилтийг хангах зарчмууд”-ыг баталсан.
- 2017 оноос жил бүр “ТХ-ийн зорилтын үйл ажиллагааны төлөвлөгөө”-г Засгийн газраас батлан хэрэгжүүлж байна.
- Японы ТХ-ийн зорилтын хэрэгжилтийн тогтолцооны өөр нэгэн онцлог нь Орон нутгийн түвшинд зарим захирагчид өөрсдийн стратеги төлөвлөгөө, хөтөлбөрөө ТХЗ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулж эхэлсэн бөгөөд үүний нэг жишээ нь ТХЗ-ын хүрээнд Ирээдүйн хотууд (SDGs Future Cities) төслүүдийг боловсруулан хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд 2019 онд Японы 29 орон нутгийн засаг захиргаа өөрсдийн ТХЗ-ын хүрээнд Ирээдүйн хотын төлөвлөгөөг боловсруулан бэлэн болгоод байна.

Суралцах зүйл

- Төрийн болон орон нутгийн удирдлага хоорондын хамтын ажиллагааг ТХЗ-ын хэрэгжилтийг нэмэгдүүлэх, уялдуулах, хөтөлбөр үйл ажиллагаанд нэвтрүүлэх

ИНДОНЕЗ



Удирдах, зохицуулах, зангидах

2017 онд Индонезийн Ерөнхийлөгчийн зарлиг (59/2017)-аар ТХ-ийн зорилтыг хэрэгжүүлэх төрийн байгууллын тогтолцоог тодорхойлсон.

Энэ тогтолцоо нь Ерөнхийлөгчийн даргалах ТХ-ийн зорилтын хяналтын хороо, Үндэсний хөгжил төлөвлөлтийн яам, түүний сайдаар толгойлуулсан ТХ-ийн зорилтыг хэрэгжүүлэх хороо болон 4 ажлын хэсгээс бүрдэнэ.

Үйл ажиллагааг хариуцан ажиллах түвшинд

Хороо болон ажлын хэсгийн гишүүдээр засгийн газар, бизнес эрхлэгчид, иргэний нийгмийн байгууллага болон академи, их сургуулиудын төлөөллийг сонгосон байдаг.

Хийсэн ажил

- Индонез улс энэ хугацаанд ТХ-ийн зорилтын замын зураг 2018-2030, болон “Тогтвортой Хөгжлийн Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө 2017-2019”-ийг батлан хэрэгжүүлж байна.
- Орон нутгийн удирдлагын төвшинд ТХ-ийн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд баримтлах зарчмыг баталсан бөгөөд үйл ажиллагааны төлөвлөгөөндөө оруулахаар ажиллаж байна.


Суралцах зүйл

- Орон нутгийн хамтын ажиллагаа, үйл ажиллагаа руу нь буусан үүрэг, хариуцлага



Тогтвортой хөгжлийн боловсролын төлөв
ХАМТЫН САНААЧИЛГА ТҮНШЛЭЛ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ САНАА: ИНСТИТУТЧИЛЭЛ, ТҮНШЛЭЛ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ



ХАМТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ШАТЛАЛ

Хэлбэр	Coordination – Зохицуулалт	Cooperation – Хамтын ажиллагаа	Collaboration – Хамтран ажиллах
Сорилт	Бага	Их	

Эрчимтэй байдал, холбоос, оролцоо, тэгш байдал /Хүчтэй улсын салбар, түншлэгчдийн хооронд/

Хэн үйлдвэрлэх вэ?

- Сайн дурынхан
- Засгийн газрын байгууллага
- Хувийн компаниуд
- ТББ-ууд

- Хувийн компаниуд
- ТББ-ууд
- Засгийн газрын байгууллагууд

- Засгийн газрын байгууллага
- Хувийн компаниуд
- ТББ-ууд
- Засгийн газрын бусад байгууллагууд
- Үйлдвэрлэгчид

Хэн шийдвэрлэх вэ?

- Засгийн газрын байгууллага

- Хамтын шийдвэр

Удирдлагын зан үйл, үйл ажиллагаа

- Хагас хөдөлмөрийн гэрээ
- Албадлага ба нийцэл
- Солилцоо

- Гэрээ
- Солилцоо
- Хамтын ажиллагаа
- Албадлага ба нийцэл

- Хэлцэл
- Хэлэлцүүлэг
- Харилцан яриа – буулт
- Хамтран бий болгох, төлөвлөх, үйлдвэрлэх

Жишээнүүд

- Сайн дурын ажил эрхлэх
- Зохицуулалтын дүрэм журам

- Төр хувийн хэвшлийн түншлэл
- Гадагш гэрээлэх

- Олон салбарын хамтын ажиллагаа



Тогтвортой хөгжлийн боловсролын төлөх
ХАМТЫН САНААЧИЛГА ТҮНШЛЭЛ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ САНАА: ИНСТИТУТЧИЛЭЛ, ТҮНШЛЭЛ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Сорилт


Бага

Их

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ҮЕ ШАТ



Lance Moir. (2006). Corporate social responsibility. UK: Cranfield University

Нийгмийн хариуцлагын идэвхгүй хэлбэрийг дараагийн шатанд гаргах нь зардал (cost), өгөөж (benefit)-д суурилсан тасралтгүй үйл явц байх учиртай. Иймд ТХ-ийн үйл ажиллагаанд түншлэлийг хэрэгжүүлэн ажиллаж буй байгууллагуудад эдийн засаг, санхүүгийн шинжтэй урамшуулал үзүүлэх хөшүүргийг бий болгох нь түншлэлийн үйл ажиллагаа идэвхтэй хэрэгжих үндэс суурь болдог. Энэ нь түншлэлийн үйл ажиллагаа онолын хувьд **win-win зарчмаар** хэрэгждэг тул түншлэгч талуудад ашигтай байх шаардлагатай нийцнэ.

Нийгмийн хариуцлагыг үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлд **УРАМШУУЛЛЫН МЕХАНИЗМ**-аас гадна **ХАРИУЦЛАГЫН МЕХАНИЗМ** чухал. Иймд төрийн байгууллага, албан тушаалтны үр дүнгийн тайлан, ажлын гүйцэтгэлийг тооцоход ТХБ-ын чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, түншлэн ажиллах санаачлагыг харгалзах явдал тогтвортой хөгжлийн чиглэлд тэргүүлэх ач холбогдол өгөх нь ТХ-ийн үзэл санааг нутагшуулахад чухал ач холбогдолтой.

ТХ-ийн асуудлыг жинхэнэ утгаар ажил хэрэг болгоход **АЛБАН БҮТЭЦ**, түүнийг дагасан **АЛБАН БУС сонирхлын бүлэг**, үүсгэл санаачлагын **НЭГЖ**-үүд бий болгох ажилд онцгой ач холбогдол өгөх нь нэн чухал.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН 4 ТАЛТ ЗАГВАР

ХАРИУЦЛАГЫН ТӨРӨЛ	НИЙГМИЙН ХҮЛЭЭЛТ	ЗАГВАР ЖИШЭЭ
Филантропийн /сайн үйлсийн, буяны шинжтэй/	ХҮСЭЛТ	○ Санхүүгийн дэмжлэг ○ Эд материалын тусламж ○ Сайн санааны үйл ажиллагаа
Ёс зүйн	ХҮЛЭЭЛТ	❖ Шүүмжлэлд өртөхүйц үйлдлээс зайлсхийх ❖ Хууль дээдлэх ❖ Хуулийг дагаж мөрдөх ❖ Ёс зүйн үлгэр дуурайл үзүүлэх
Эрх зүйн	ЗААВАЛ МӨРДӨХ	✓ Холбогдох хууль дүрмийг сахин биелүүлэх ✓ Байгаль орчныг хамгаалах тухай хууль ✓ Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль ✓ Хөдөлмөрийн тухай хууль ✓ Авилгатай тэмцэх тухай хууль ✓ Гэрээгээр хүлэсэн үүргээ биелүүлэх
Эдийн засгийн	ЗАЙЛШ-ГҮЙ БИЕЛҮҮ-ЛЭХ	➢ Үр ашигтай үйл ажиллагаа явуулах ➢ Борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх ➢ Зардлыг бууруулах /захиргаа, үйлдвэрлэл, маркетинг, түгээлт/ ➢ Стратегийн ухаалаг шийдвэр гаргах ➢ Ногдол ашиг хуваарилах ➢ Бодлогод мэдрэмжтэй хандах

Maureen C.Shaw. (2006). Corporate social responsibility: A new paradigm. Spain: Industrial Accident Prevention Association. 2006

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ САНАА: ИНСТИТУТЧИЛЭЛ, ТҮНШЛЭЛ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ



№	Байгууллагууд		УИХ, ЗГ, Яамдын түвшинд	Мэргэжлийн байгууллагуудын түвшинд	Орон нутгийн удирдлагын түвшинд	Сургалтын байгууллагуудын түвшинд
	Хэрэгжүүлэх чиглэл		- Тогтвортой хөгжлийн Дэд хороо - Тогтвортой хөгжлийн Үндэсний хороо - Үндэсний хөгжлийн газар - Үндэсний статистикийн хороо - Яамдууд, Төрийн байгууллагууд	- Байгаль орчны чиглэлээр ажилладаг мэргэжлийн байгууллагууд - Боловсролын чиглэлээр ажилладаг мэргэжлийн байгууллагууд - ТББ – мэргэжлийн чиглэл бүрээр	- Орон нутгийн удирдлага - Захиргааны байгууллагууд	- Сургуулийн өмнөх боловсролын байгууллага - Ерөнхий боловсролын сургууль - Их дээд сургууль - Сургалтын бусад байгууллагууд
1	Судалгаа		ТХ-ийн тодорхой асуудлаар судалгаа захиалах, хамтарч ажиллах	ТХ-ийн нарийвчилсан агуулгаар судалгаа, үнэлгээ хийх, Судалгааны үр дүнг сурталчилах, Судалгааны үр дүнд тулгуурлан нөлөөллийн арга хэмжээ авах	ТХ ба орон нутгийн онцлогийг харгалзан хийх судалгааны хэрэгцээгээ тодорхойлох, мэдээлэх	ТХ-ийн судалгаа хийх арга зүй, ур чадвар эзэмшүүлэх
2	Төлөвлөлт		Төрийн бодлогоор дэмжих, албан ёсны бүтэц, зохицуулалттай болох, үүнийг төрийн бус байгууллагуудын сүлжээ, хамтын ажиллагаа, олон нийтийн санал санаачилгаар дэмжих	Төрийн байгууллагын бодлого, шийдвэрийг ТББ-уудын сүлжээ, хамтын ажиллагаа, олон нийтийн санал санаачилгаар дэмжих, Их дээд сургуулиудыг түшиж, хамтарч ажиллах	Орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгах	Судалгааны их сургууль болох зорилттой уялдуулан санал санаачилгыг хэрэгжүүлэх, ТХ-ийн зорилго, зорилт тус бүрээр хийх сургалт судалгааны ажлыг хийх, боловсролын зэрэг олгох хөтөлбөр бий болгох
3	Хэрэг-жилт	Бүтэц механизм	ТХ-ийн нийтлэг үнэт зүйлс дээр нэмээд бүс нутаг, үндэстэн, угсаатан, орон нутгийн хэрэгцээ, соёлын онцлогийг сайтар тооцож, шинжлэх ухаанд үндэслэсэн судалгаанд суурилсан ТХ-ийн төлөө боловсролын тогтолцоогоо хөгжүүлэх	Салбар дундын хамтын ажиллагааны хүрээнд зөвлөл, сүлжээ, мэдээллийн платформ байгуулан, үйл ажиллагааг тогтмолжуулах		
4		Хүний нөөц	ТББ-ын ТХ-ийн талаарх санал санаачилгыг дэмжих, идэвхжүүлэх, ТХБ-ыг дэмжих сантай болох	ТХ-ийг түншлэл, хамтын ажиллагаагаар дамжуулан, нэгдсэн зохион байгуулалт харилцан дэмжлэгийн хүчээр нийтлэг зорилгодоо хүрэх		
5		Санхүүжилт	Олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг амлалтаа биелүүлж, тайлагнах, төсөл хэрэгжүүлэх замаар олон улсын байгууллага, донор, сангийн дэмжлэг авах			
6	Хяналт – шинжилгээ үнэлгээ – тайлагналт		ТХБ-ыг хэмжих индекс үзүүлэлтийн системтэй болж, улс орнуудтай харьцуулан үнэлж, уг үнэлгээнд үндэслэн тодорхой үзүүлэлтүүдийг сайжруулан, өрсөлдөх чадвараа ахиулах			
7	Ухуулга сурталчилгаа		ТХБ-ыг дэмжих сургалт судалгаа, мэдээлэл харилцаа, мэдлэг солилцооны үүргийг бодит үйл хэрэг болгох			Дэлхий дахинаа 170 сая гаруй оюутан их дээд сургууль төгссөний ихэнх нь ТХ-ийн талаар огт судлахгүйгээр төгссөн байна.

Институтчилэх үүднээс юу хийх хэрэгтэй вэ?



Тогтвортой хөгжлийн боловсролын төлөх
ХАМТЫН САНААЧИЛГА ТҮНШЛЭЛ


ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ САНАА: ИНСТИТУТЧИЛЭЛ, ТҮНШЛЭЛ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ



Үндэсний хэмжээнд дагаж мөрдөх бодлогын баримт бичгийг бодит ажил болгон хэрэгжүүлэхэд салбар дундын зохицуулалт, хамтын ажиллагаа нэн чухал болно.



Эдийн засаг, байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан салбарын яамд тэргүүлэх үүргийг гүйцэтгэж манлайлах нь удирдлага, зохион байгуулалт, хэрэгжилтийг үр дүнтэй болгоход чухал ач холбогдолтой хэдий ч төрийн бүх байгууллагын хамтын ажиллагаа илүү чухал болохыг ухаарч ажиллах хэрэгтэй байна.



Салбарын тодорхой яамд манлайлах үүргээ хэрэгжүүлэхэд дараах ажлуудыг хийдэг туршлага байна. Үүнд:

- Тогтвортой хөгжлийн талаарх бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг зангидаж, нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт үнэлгээ хийх үүрэг бүхий “Салбар дундын зөвлөл” байгуулан ажиллуулах.
- Эсвэл салбар дундын серверийн үүрэг бүхий нэгж байгуулах:
 - Тухайн асуудлаар дэмжлэг үзүүлэх, интервенц хийх
 - Тухайн асуудлаар заавар бэлтгэх, олон нийтэд хүргэх, таниулах
 - Мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх
 - Гол оролцогч талуудыг холбох.
- Тогтвортой хөгжлийн боловсролд зориулсан судалгаа, мэдээ, мэдээллийн нэгдсэн сан, талбар бий болгох, эргэлтэд оруулах:
 - Бусад орны туршлага, сургамжаас суралцахын хамт өөрийн орны онцлог, нийгмийн бүлгийн шинжийг сайтар тооцон үзсэн судалгаа хийх, судалгааны үр дүнг олон нийтэд хүртээмжтэй болгох
 - Тогтвортой хөгжлийн боловсрол олгох мэдээ, мэдээллийн сувгийг төв суурин, хөдөө орон нутгийн онцлогийг харгалзан оновчтой тогтоон хэрэглэх
 - Тогтвортой хөгжлийн талаарх бодлогын баримт бичиг, дүрэм журам, стандартын нэгдмэл сан бий болгох, платформ байгуулах, иргэдэд хүртээмжтэй байлгах зэрэг болно.

- ТХБ-ын хэрэгжилтэд оролцогч талуудын хандлага, хэрэгцээ сонирхол, үүрэг хариуцлагыг тодорхойлох үндсэн дээр оролцогч талуудын идэвхтэй оролцоо, нягт хамтын ажиллагаа-г өрнүүлэх нь зайлшгүй чухал.
- Бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч, иргэний нийгмийн байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, судлаач, аж ахуйн нэгж, олон улсын байгууллага, боловсролын байгууллагын багш, ажилтан, суралцагч, жирийн иргэдийн үүрэг, оролцоо анхнаасаа тодорхой байх нь чухал.
- Оролцогч талуудын оролцоо нь давхцалгүй, харилцан сул талаа даван туулах, нөхөн гүйцээх шинжтэй байх нь үр ашигтай хамтын ажиллагааны суурь болно.
- ТХ-ийн талаарх мэдлэг, мэдээллийг боловсролын шатлалын дагуу иргэдэд олгохдоо бүх шатны боловсролын байгууллагын албан болон албан бус сургалт үйл ажиллагаагаар ухамсар хандлага төлөвшүүлэхээс эхлээд мэдлэг, чадвар эзэмших, бүтээлч сэтгэх, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах хүртэлх чадамжийг эзэмшихүйц байдлаар системтэй тусгах нь чухал.



Тогтвортой хөгжлийн боловсролын төлөв
ХАМТЫН САНААЧИЛГА ТҮНШЭЭЛ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ САНАА: ИНСТИТУТЧИЛЭЛ, ТҮНШЛЭЛ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ

№	Байгууллагууд		УИХ, ЗГ, Яамдын түвшинд	Мэргэжлийн байгууллагуудын түвшинд	Орон нутгийн удирдлагын түвшинд	Сургалтын байгууллагуудын түвшинд
	ТХ-ийн 3 тулгуурын хүрээний чиглэлүүд		- Тогтвортой хөгжлийн Дэд хороо - Тогтвортой хөгжлийн Үндэсний хороо - Үндэсний хөгжлийн газар - Үндэсний статистикийн хороо - Яамдууд, Төрийн байгууллагууд	- Байгаль орчны чиглэлээр ажилладаг мэргэжлийн байгууллагууд - Боловсролын чиглэлээр ажилладаг мэргэжлийн байгууллагууд - ТББ – мэргэжлийн чиглэл бүрээр	- Орон нутгийн удирдлага - Захиргааны байгууллагууд	- Сургуулийн өмнөх боловсролын байгууллага - Ерөнхий боловсролын сургууль - Их дээд сургууль - Сургалтын бусад байгууллагууд
1	НИЙГЭМ	Ажлын байр				
2		Мэргэжилтэн				
3		Хөрөнгө оруулалт				
4		ТББ-тай хамтрах				
5	ЭДИЙН ЗАСАГ	Инноваци				
		Байгалийн нөөц үр ашиг				
6	БАЙГАЛЬ ОРЧИН	Байгаль орчинд халгүй үйл ажиллагаа				
7		Байгаль орчны удирдлагын тогтолцоо				

ТХ-ийн гурван тулгуурт суурилж юу хийх хэрэгтэй вэ?

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ САНАА: ИНСТИТУТЧИЛЭЛ, ТҮНШЛЭЛ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ



Тогтвортой хөгжлийн боловсролын төлөх
ХАМТЫН САНААЧИЛГА ТҮНШЛЭЛ

№	Байгууллагууд		УИХ, ЗГ, Яамдын түвшинд			Мэргэжлийн байгууллагуудын түвшинд			Орон нутгийн удирдлагын түвшинд			Сургалтын байгууллагуудын түвшинд		
			- Тогтвортой хөгжлийн Дэд хороо - Тогтвортой хөгжлийн Үндэсний хороо - Үндэсний хөгжлийн газар - Үндэсний статистикийн хороо - Яамдууд, Төрийн байгууллагууд			- Байгаль орчны чиглэлээр ажилладаг мэргэжлийн байгууллагууд - Боловсролын чиглэлээр ажилладаг мэргэжлийн байгууллагууд - ТББ – мэргэжлийн чиглэл бүрээр			- Орон нутгийн удирдлага - Захиргааны байгууллагууд			- Сургуулийн өмнөх боловсролын байгууллага - Ерөнхий боловсролын сургууль - Их дээд сургууль - Сургалтын бусад байгууллагууд		
	ТХ-ийн 3 тулгуурын хүрээний чиглэлүүд		Хэрэгжи-хүйц	Хүртээмж-тэй	Оршин тогтнохуйц	Хэрэгжи-хүйц	Хүртээмж-тэй	Оршин тогтнохуйц	Хэрэгжи-хүйц	Хүртээмж-тэй	Оршин тогтнохуйц	Хэрэгжи-хүйц	Хүртээмж-тэй	Оршин тогтнохуйц
1	НИЙГЭМ	Ажлын байр												
2		Мэргэжилтэн												
3		Хөрөнгө оруулалт												
4		ТББ-тай хамтрах												
5	ЭДИЙН ЗАСАГ	Инноваци												
		Байгалийн нөөц үр ашиг												
6	БАЙГАЛЬ ОРЧИН	Байгаль орчинд халгүй үйл ажиллагаа												
7		Байгаль орчны удирдлагын тогтолцоо												

ТХ-ийн гурван тулгуурт суурилж хийж байгаа үйл ажиллагаа бүртээ зарчмын хувьд юу анхаарах вэ?



Тогтвортой хөгжлийн боловсролын төлөв
ХАМТЫН САНААЧИЛГА ТҮНШЛЭЛ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ САНАА: ИНСТИТУТЧИЛЭЛ, ТҮНШЛЭЛ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Тогтвортой хөгжил гэдэг аливаа үзэгдлийг “тогтолцоонд нь харж сэтгэн танин мэдэх, өөрчлөн шинэчлэх, үнэлэн сайжруулах” үйлүүд байдаг тул бүхэлд нь харах-гүйгээр урагшлахгүй нь гэдгээ бүгд ойлгож эхэлсэн байна.

Харьцуулан судалж суралцах санаа авах туршлагааудаас:

- Улс орныхоо урт хугацааны бодлоготой нийцсэн үр дүнтэй удирдлагын хамгийн үр өгөөжтэй тогтолцоог бүтээж амьд ажиллуулах
- Тогтвортой хөгжилд нийгмийн бусад салбарын үүрэг хариуцлагыг тодорхой болгож үүрэгжүүлэх
- Төрийн болон орон нутгийн удирдлага хоорондын хамтын ажиллагааг ТХЗ-той уялдуулах, тэдгээрийн хөтөлбөр үйл ажиллагаанд нэвтрүүлэх
- Орон нутгийн хамтын ажиллагаа, үйл ажиллагаа руу нь буусан үүрэг, хариуцлагыг тодорхой болгох
- Гадаад бодлогын хүрээнд тогтвортой хөгжлийг дэмжих тал дээр хүрсэн түвшнээсээ ахих хэрэгтэй байна.

Тогтвортой хөгжлийн асуудал бол зөвхөн байгаль орчин, боловсролын салбартай хамааралтай асуудал биш бүх салбар, улс орны хэмжээний асуудал тул бүх түвшин, салбарыг хамарсан цогц үйл ажиллагаа байх ёстой. Түүнийг зохицуулах, өөрийгөө бие даан аваад явах механизм-ыг бүтээх, өнөөдөр байгааг илүү амьд болгох /Институтчилэх/ хэрэгтэй байна.

ТХ, ТХБ-ын асуудал сектор дамнасан асуудал учир олон улсын хамтын ажиллагаа, үндэсний болон орон нутгийн түвшний захиргааны болон мэргэжлийн байгууллагууд, сургалтын болон бусад бүх нэгж байгууллага, аж ахуйн нэгжүүдийн түвшин бүрд харгалзсан түншилэлийг бэхжүүлэх арга механизмуудыг бий болгож ажиллах

Тогтвортой хөгжлийн зорилтод хүрэх ажлын үр дүн хувь хүний үйлдэлтэй шууд холбоотой. Хэдийгээр НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, БАЙГАЛЬ ОРЧИН гэсэн гурван тулгуурт суурилах боловч үйлдэл дээрээ хувь хүний соёлын, хэрэглээний, зан заншлын, ёс суртахууны асуудал болж байна. Тиймээс хувь хүнийг сургахад бүх түвшний оролцоог тодорхой болгох

Монгол улсын ТХ-ийн зорилтыг хэрэгжүүлж буй төрийн болон орон нутгийн үйл ажиллагааг МАТРИКС загварыг ашиглан үнэлэх. Үйл ажиллагаагаа ТХ-ийн зорилтуудыг хангаж байгаа эсэхэд өөрийн үнэлгээ, дүгнэлт хийж алдаа оноогоо мэдэрч засч залруулаад явах боломжийг бүтээх хэрэгцээ шаардлагууд тулгамдаад байна.



Тогтвортой хөгжлийн боловсролын төлөв
ХАМТЫН САНААЧИЛГА ТҮНШЭЭЛ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ – МОНГОЛ УЛСАД НОГООН ХӨГЖИЛ – 2014 /УИХ-ын 43 дугаар тогтоол/

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН
БОЛОВСРОЛ II
ТӨСӨЛ

НОГООН ЭДИЙН ЗАСАГ

Байгаль орчны эрсдэл, доройтлыг багасгахын зэрэгцээ хүний сайн сайхан байдал, нийгмийн тэгш хүртээмжтэй байдлыг сайжруулах зорилго бүхий эдийн засгийг;

НОГООН ӨСӨЛТ

Хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалах, нийгмийн оролцоог дэмжих, хүлэмжийн хийн ялгарал багатай эдийн засгийн өсөлтийг;

НОГООН ҮЙЛДВЭРЛЭЛ

Эрчим хүч, нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд эрсдэлгүй үйлдвэрлэлийн үйл ажиллагааг;

НОГООН АЖИЛ

Эрчим хүч, түүхий эд материал, усны хэрэглээг багасгах, хүлэмжийн хийн ялгарлыг хязгаарлах, хог хаягдал, бохирдлыг бууруулах, экосистемийг хамгаалж нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох замаар хүрээлэн байгаа орчны чанарыг сайжруулж, хамгаалахад чиглэсэн ажил хөдөлмөрийг;

1

2

3

4



8

7

6

5

НОГООН САНХҮҮЖИЛТ

Байгалийн нөөц баялаг, экосистемийн үйлчилгээний үнэ цэнийг хадгалж, эрчим хүч, түүхий эд материал, усны хэрэглээг багасгах технологи ашиглах төсөл, үйл ажиллагааг санхүүжүүлэх, тэдгээрт хөрөнгө оруулахыг;

НОГООН ХУДАЛДАН АВАЛТ

Эрчим хүч, байгалийн нөөц баялгийн хэмнэлттэй хэрэглээ, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хангах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг;

НОГООН БАРИЛГА

Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөгүй материал ашигласан, дулааны алдагдал хамгийн бага байх хийцтэй, агаарт ялгаруулах хаягдал багатай халаалтын шийдэлтэй, эрчим хүч, нөөцийн хэмнэлт үр ашигтай, хур тунадасны усыг хуримтлуулж ашиглах, хаягдал бохир усаа цэвэрлэж зайлуулах технологи бүхий, тав тухтай орчныг бүрдүүлсэн барилга байгууламжийг;

НОГООН ХОТ

Эрчим хүч, дулаан, ус хангамж, харилцаа холбоо, нийтийн тээврийн ухаалаг дэд бүтэц, хог хаягдлын оновчтой менежмент бүхий хүний амьдралын тав тух, хөгжлийн боломжийг хангасан хот сууринг;



Тогтвортой хөгжлийн боловсролын төлөөх
ХАМТЫН САНААЧИЛГА ТҮНШЛЭЛ



**АНХААРАЛ ТАВЬСАНД ТАЛАРХАЛ
ИЛЭРХИЙЛБЕ!**